

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

№ 2025/44-10

2025 оны 05 дугаар сарын 02 өдөр

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Цаг уур, орчны шинжилгээний газар /цаашид ЦУОШГ гэх/, түүнийг төлөөлж газрын дарга Э.Баттулга, нөгөө талаас ХААИС-ийн Дархан дахь салбар Агроэкологи, бизнесийн сургууль /цаашид АЭБС гэх/, түүнийг төлөөлж захирал П.Ганхуяг нар /хамтад нь "Талууд" гэх/ дор дурдсан нөхцөлөөр хамтран ажиллахаар харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1.1. Гэрээний зорилго нь байгаль, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын гэрээ конвенц, Монгол Улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. ЦУОШГ-ын эрх, үүрэг

2.1.1. Эрдэм шинжилгээ, сургалт, үйлдвэрлэлийн хамтын ажиллагааны экосистемийг бий болгоход дэмжлэг үзүүлэх;

2.1.2. Гадаад, дотоод хамтын ажиллагааг идэвхжүүлэх замаар салбар дундын судалгаа хөгжүүлэлт, сургалтын платформыг олон улсын жишгээр бүс нутаг, үндэсний болон олон улсын түвшинд хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

2.1.3. Салбарын үйл ажиллагааны олон улсын стандарт, арга зүйг сургалт, судалгаанд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

2.1.5. АЭБС-ийн сургалт, судалгаа, үйлдвэрлэлийн дадлагын дэд бүтцийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;

2.1.6. Багш, судлаачдыг салбарын түвшинд нэвтрүүлж байгаа шинэ стандарт, арга зүй, техник, технологийг эзэмшихэд дэмжлэг үзүүлэх;

2.1.7. Сургуулийн хэрэгжүүлж буй олон улсын сургалт, судалгааны арга, арга зүйг дэмжих замаар мэргэжлийн ур чадвар сайтай хүний нөөцийг бэлтгэхэд хамтран ажиллах;

2.1.8. Цаг уур, ус судлалын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд санал өгөх;

2.1.9. Бакалавр, магистрын судалгааны ажилд шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах;

2.1.10. Суралцагсдын сургалт, үйлдвэрлэлийн дадлагыг хийх нөхцөл, боломжоор хангах;

2.1.11.ЦУОШГ-ын болон харьяа байгууллагын албан хаагчдыг цахимаар суралцах үед сургуулийн зүгээс тогтоосон хугацаанд цалинтай чөлөө олгон ирүүлж байх;

2.1.12.Төгсөгчдийг ажлын байраар хангах, хүний нөөцийг чадавхжуулах богино хугацааны сургалтыг оновчтой хэлбэрээр тогтмол зохион байгуулж байх;

2.1.13.Ус цаг уур, орчны шинжилгээний салбарт ажиллаж байгаа суралцагсдын суралцах хугацааны мэдээллийг авах.

2.2. Сургуулийн эрх, үүрэг

2.2.1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталдаг үлгэрчилсэн журмын дагуу Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын шаардлага, шалгуур үзүүлэлтүүдэд нийцүүлэн сургалтын төлөвлөгөө, сургалтын арга, арга зүй, төгсөгчийн загвараа шинэчлэн сайжруулах;

2.2.2. Салбарын хүний нөөцийн ажлын байрны тодорхойлолтод нийцүүлэн бичил кредитийн сургалтын хөтөлбөр, дадлагын удирдамжийг ажил олгогчтой зөвшилцөж боловсруулж мөрдөх;

2.2.3. Сургалтыг танхим, цахим, хосолсон хэлбэрээр суралцагчийн мэдлэг чадвар, ажил олгогчийн хүсэлтийг харгалзан зохион байгуулах;

2.2.4. Сургалтын дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар дэд бүтцийг байнга шинэчлэх;

2.2.5. Мэргэжлийн багш, судлаачдын ажлын нөхцөл, нийгмийн асуудлыг үе шаттай шийдвэрлэхийн зэрэгцээ мэргэжлийн чадвар, сургалт судалгааны арга зүйг байнга дээшлүүлэх;

2.2.6. Ус цаг уур, орчны шинжилгээний салбарт ажиллаж байгаа цахим сургалтад хамрагдаж байгаа суралцагсдад зориулсан төлөвлөгөөг албан бичгээр харьяалагдах байгууллагад хичээлийн жилийн эхэнд хүргэх;

2.2.7. 2.1.9-д заасны дагуу судалгааны ажилд зориулж Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний анхан шатны мэдээ мэдээллийг авсан тохиолдолд зөвхөн тухайн судалгааны ажилд ашиглах, судалгааны ажлын үр дүнг хүргүүлэх;

2.2.6. Гадаад, дотоод хамтын ажиллагаанд суурилсан салбар дундын судалгаа хөгжүүлэлтийг олон улсын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх замаар гүйцэтгэх;

2.2.7. Салбарын мэргэжлийн байгууллагуудтай хамтран хүний хөгжлийг дэмжин олон талт арга хэмжээг зохион байгуулах.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

3.1. Гэрээ нь батлагдсан өдрөөс эхлэн 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

3.2. Аль нэг тал гэрээг цуцлах хүсэлт гаргаагүй тохиолдолд гэрээ дараагийн 3 жилээр сунгасанд тооцно.

ДӨРӨВ. БУСАД ЗҮЙЛ

4.1. Энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр мөрдөж эхэлнэ.


4.2. Аль нэг тал гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн байгуулах, цуцлах тухай саналаа нөгөө талд бичгээр мэдэгдэж, талууд харилцан тохиролцсоны дагуу асуудлыг шийдвэрлэнэ.

4.3. Давагдашгүй хүчин зүйлээс бусад тохиолдолд маргаантай асуудал үүсвэл талууд зөвшилцлийн замаар шийдвэрлэнэ.

4.4. Хамтын ажиллагааны явцад талууд хамтран хэрэгжүүлж буй үйл ажиллагааны тухай мэдээллүүдийг харилцан нээлттэй, үнэн зөв солилцоно.

4.5. Гэрээг 2 хувь үйлдэж, талууд хадгална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА  Э.БАТТУЛГА



ХААИС-ИЙН ДАРХАН-УУЛ АЙМАГ
ДАХЬ САЛБАР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ  П.ГАНХУЯГ

